



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 01 сарын 26 өдөр

Дугаар А/58

Арвайхээр сум


Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Барилга, хот байгуулалтын сайдын 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн “Барилгын захиалагчийн хяналтын талаар авах зарим арга хэмжээний тухай” 83 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл арга хэмжээний хяналтыг хэрэгжүүлэхэд шаардагдах тоног төхөөрөмж, шатахуунаар хангах зардлыг хавсралтаар баталсугай.

2. Хавсралтад тусгагдсан 33,580,340 (гучин гурван сая таван зуун наян мянга гурван зуун дөч) төгрөгийг захиалагч хяналтын зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



И.ДОРЖСҮРЭН

0224 11 0125

Аймгийн Засаг даргын 2024 оны дүгээр
сарын 06 -ны өдрийн 1158 дугаар
захирамжийн хавсралт



ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЖАГСААЛТ

№	Тоног төхөөрөмжийн нэр	Тоо хэмжээ	Үнэ	Нийт үнэ
1.	Техник хяналт хэрэгжүүлэх багаж хэрэгсэл	2	1,440,000	2,880,000
2.	Зөөврийн компьютер	4	3,500,000	14,000,000
3.	Суурин компьютер	2	4,000,000	8,000,000
4.	Сканнер	1	3,000,000	3,000,000
5.	Өнгат принтер	1	1,200,000	1,200,000
6.	Шатахуун	1822	2470	4,500,340
	Нийт			33,580,340

-oOo-